Агуулга

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 3

1.1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ 3
1.2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА 3

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 13

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ 15

ТОДОРХОЙЛОЛТ 15

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 18

БҮЛЭГ 5.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 19

БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ ТӨЛӨВЛӨГӨӨ 21

БҮЛЭГ 7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 21

БҮЛЭГ 8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 21

БҮЛЭГ 9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 22

БҮЛЭГ 10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 23

БҮЛЭГ 11. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР 24

БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ 26

БҮЛЭГ 13.ТУХАЙН ЖИЛ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ. 27

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ, ДҮГНЭЛТ 28

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих талбайн координат 3
Хүснэгт 2. Баазын барилга байгууламж / мянган төгрөг/ 7
Хүснэгт 3. Үйл ажиллагааны зардал /мян.төг/ 7
Хүснэгт 4. Орлогын тооцоо/ мян.төг/ 7
Хүснэгт 5. 4*5 Дүнзэн байшингийн тохижуулалт 7
Хүснэгт 6. Нийтийн боловсон ариун цэврийн газар 8
Хүснэгт 7. Ундны усны хэрэглээний тооцоо 10
Хүснэгт 8. Ногоон байгууламж байгуулахад шаардагдах усны хэрэглээ 11
Хүснэгт 9. Усны 5 жилийн нийт хэрэглээ 11
Хүснэгт 10. Ажиллах хүчний тоо 12
Хүснэгт 11. *Байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын хураангуй* 13
Хүснэгт 12. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нөлөөлөл хоорондын уялдаа 15
Хүснэгт 13. *Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө* 19
Хүснэгт 14. *Нөхөн сэргээх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө* 21
Хүснэгт 15. Осол эрсдэлийг бууруулах,урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 22
Хүснэгт 16. *Хог хаягдлын сөрөг нөлөөллийг арилгах бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө* 23
Хүснэгт 17. *Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр* 24
Хүснэгт 18. *Удирдлага зохион байгуулалтаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө* 26
Хүснэгт 19. *Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө* 27
Хүснэгт 20. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт 28

Зургийн жагсаалт

Зураг 1. Төслийн талбайн одоогийн байдал 4
Зураг 2. Төслийн талбайн байршил 4
Зураг 3. Төслийн төлөвлөлт 5
Зураг 4.Худгийн байршил 10

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр:	Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн тур буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтай орон байр барих, ашиглах төсөл
Төслийн байршил	Улаанбаатар хотын Налайх дүүргийн 6-р хорооны газар нутаг Горхи Тэрэлжийн байгалийн цогцолборт газар, Горхийн зүүн салаа нэртэй газар 5000 м^2 талбайд байрлана.
Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: Улсын бүртгэлийн гэрчилгээ: Регистрийн дугаар :	“Их халзан сүлжээ” ХХКомпани 9011652132 рд 6197604
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 12-р хороо, жанжин 23, 482тоот Утас: 91918456, 80088456

1.2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төслийн зорилго: "Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн тур буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтай орон байр барих, ашиглах төсөл" байгуулж гадаадын амрагч, жуулчид, иргэдийн амрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, олон улсын жишиг стандарт, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн иж бүрэн үйлчилгээг үзүүлэх, аялал жуулчлалын цогцолбор байгуулж, тухайн газар нутгийг хариуцан хамгаалж, экологийн цэвэр орчныг хангах, ажлын байрыг нэмэгдүүлэхэд оршино.

Төслийн байршил: Улаанбаатар хотын Налайх дүүргийн 6-р хорооны газар нутаг Горхи Тэрэлжийн байгалийн цогцолборт газар, Горхийн зүүн салаа нэртэй газар 5000 м^2 талбайд байрлана.


Хүснэгт 1. Төсөл хэрэгжих талбайн координат

№	Талбайн солбицол	
	Уртраг	Өргөрөг
1	5308543.200	680627.700
2	5308597.840	680607.900
3	5308610.115	680686.857
4	5308528.830	680754.400
5	5308493.642	680728.662
6	530521.845	680688.624
7	5308556.057	680638.300

Зураг 1. Төслийн талбайн одоогийн байдал



Зураг 2. Төслийн талбайн байршил




2.2. Төслийн хүчин чадал

Ажиллагсдын хувьд Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн тур буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтай орон байр барих, ашиглах төсөл нь нийтдээ 20 ажиллагсадтай үйл ажиллагаа явуулах бөгөөд ажиллах хүчний тоо улирлаас хамааран байнгын болон түр байдлаар жилд 10 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулахаар төсөл боловсруулсан байна. Цахилгаан эрчим хүчний хувьд нэгдсэн сүлжээнээс хангагдах бөгөөд нарны эрчим хүчийг ашиглан цахилгаан халаагуур ашиглаж харилцаа холбооны хувьд үүрэн телефон ашиглах бүрэн бололцоотой байна.

Төслийн үйл ажиллагаанд 1 ширхэг 5*6 харьцаатай зочны байшин байгуулахаар төлөвлөөд байна. Нэг ээлждээ 50-60 хүн хүлээн авах хүчин чадалтай 10 ажилтантайгаар тогтмол үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн байна.

Зураг 3. Төслийн төлөвлөлт







Төслийн ялгарах онцлог талууд.
Техник технологи:

- Өндөр хурдны интернэт
- Фото болон видео бичлэгийн үйлчилгээ

Алжаал тайлах үйлчилгээ:

- Саун
- массаж

Үйлчилгээ:

- Хувийн унаа тэргээр хүргэх үйлчилгээ
- Интернэт, утас, факс болон и-мейлээр захиалга

Аюулгүй байдал:

- 24-н цагийн харуул хамгаалалт
- Камер

Спорт:

- Биллиард, теннисний ширээ
- Шатар, даам, даалууны ширээнүүд

Хоол:

- Шинэхэн айраг
- Жилийн дөрвөн улиралд ажилладаг:
- Өвлийн улиралд амралт болон цанын бааз болно
- Зуны улиралд бүрэн ажиллана

Төслийн техник технологи, эдийн засгийн үзүүлэлт

Ажиллагсдын хувьд Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн тур буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтай орон байр барих, ашиглах төсөл нь нийтдээ 20 ажиллагсадтай үйл ажиллагаа явуулах бөгөөд ажиллах хүчний тоо улирлаас хамааран байнгын болон түр байдлаар жилд 10 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулахаар төсөл боловсруулсан байна.

Хүснэгт 2. Баазын барилга байгууламж / мянган төгрөг/

№	**Нэр төрөл**	**Хэмжих нэгж**	**Тоо**	**Нэгж үнэ**	**Бүгд үнэ**
1	4*5 байшин	ш	6	10,000,0	10,000,0
2	Рестораны гэр'	ш	1	4,000,0	4,000,0
3	Гал тогооны байр, агуулах	ш	1	6,000,0	6,000,0
4	Гүний усны худаг	м	1	7,000,0	7,000,0
5	Хамгаалалтын хашаа барих	м	1248		10,000,0
6	Цахилгаан шугам татах	м	150		4,200,0
7	Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээнд				15,000,0
	Бүгд				**56,200,0**

Энэхүү баазыг байгуулахад нийт 56,200,000 төгрөг шаардагдах бөгөөд үүний тал хувийг банкны зээлээр үлдсэн тал хувийг байгууллагын санхүүжилтээр хийхээр төсөлд тусгасан байна.

Хүснэгт 3. Үйл ажиллагааны зардал /мян.төг/

№	Нэр төрел	Хэмжих нэгж	тоо	Нэгж үнэ	Бүгд үнэ
1	Хоол хүнсний материалын тооцоо	Хүн/ дун хоног	100х3 хоног	9,0	2,700,0
2	Шатах тослох материалын тооцоо	л	1800	-	1,176,0
3	Эргэлтийн хөрөнгө	-	-	-	8,436,2
4	Цалин хөлс	Сар	4-12	710,0	3,640,0
5	Татварын хэлтэс	-	-		1,291,0
	Бүгд				182130

Орлогын төлөвлөгөө

Хүснэгт 4. Орлогын тооцоо/ мян.төг/

№	Нэр төрөл	Хэмжих нэгж	**Тоо**	Нэгж үнэ	Бүгд үнэ
1	Хоол байр үйлчилгээний орлого	Хүн /дун.хоног/	100х3 хоног	40,0	12,000,0
2	Ресторан баарны үйлчилгээний орлого	-	-	-	17,850,0
3	Нэмэлт үйлчилгээний орлого	-	-	-	9,500,0
	Бүгд				**39,350,0**

Хүснэгт 5. 4*5 Дүнзэн байшингийн тохижуулалт

№	Материал	Хэмжих нэгж	**Тоо** хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ

2	"Өргөө" хивс	ш	10	300,000	3,000,000
3	Хөнжил	ш	50	40,000	2,000,000
4	Гудас	ш	30	20,000	600,000
5	Ор хөнжлийн даавуу	ш	50	18,000	900,000
6	Гар нүүрийн алчуур	ш	50	5,000	250,000
7	Орны бүтээлэг	ш	30	25,000	750,000
8	Дэр	ш	30	15,000	450,000
9	Толь	ш	10	20,000	200,000
10	Цаг	ш	10	5,000	50,000
11	Цахилгааны хэрэгсэл	багц	10	200,000	2,000,000
12	Угаалтуур	ш	10	250,000	2,500,000
	Нийт үнэ				**12,700,000**

Хүснэгт 6. Нийтийн боловсон ариун цэврийн газар

№	**Материал**	**Хэмжих нэгж**	Тоо **хэмжээ**	**Нэг бүрийн үнэ**	**Нийт үнэ**
1	Тоосго	ш	32,600	120	3,912,000
2	Цемент	тн	3	90,000	252,000
3	Цонхны шил	м2	12	75,000	900,000
4	Хаалга	ш	3	200,000	600,000
5	Банз	м3	20	90,000	1,800,000
6	Будаг	кг	8	2,500	20,000
7	Замаск	кг	400	200	80,000
8	Эмульс	кг	50	2,500	125,000
9	Хар тос	кг	600	180	108,000
10	Труба	тн	1	618,000	432,600
11	Плита	ш	1,500	260	390,000
12	Угаагуур	ш	6	250,000	1,500,000
13	Суултуур	ш	6	150,000	900,000
14	Шүршүүр	ком	3	25,000	75,000
15	Хувцасны өлгүүр	ш	3	15,000	45,000
16	Толь	м2	15	2,500	37,500
	Нийт үнэ				**11,177,100**

Завсрын бүтээгдэхүүн, хог хаягдлын тооцоо

Төсөл хэрэгжих явцад гарах хог хаягдалыг гарал үүслээр нь:

- Барилга байгууламж барих явцад гарах хог хаягдал

Амралтын үйл ажиллагааны явцад гарах хог хаягдал, Хэлбэрээр нь :

- Хатуу хог хаягдал
- Шингэн хог хаягдал
- Хийн хаягдал гэж ангилна.

Хатуу хог хаягдал

Барилга байгууламж барихад гарах хатуу хог хаягдал нь :

- Барилгын материалын үлдэгдэл
- Ажилчдын ахуйн хэрэглээний хог хаягдал байна.

Тус Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн тур буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтай орон байр барих, ашиглах төсөл нь бүрэн хүчин чадлаараа ажиллана гэж тооцвол хоногт 67.5кг, 30 хоногт буюу сард 2025 кг, жилд буюу 365 хоногоор тооцож үзвэл 18.5 тн орчим хатуу хог хаягдал гаргахаар байна. Дээрх тооцоог нэг өдөрт дунджаар 0.25 кг хатуу хог хаягдал гаргахаар хийв. Бүрэн хүчин чадал гэдэгт нийт 225 хүнийг оруулах бөгөөд үүнийг өдрийн амрагч 60, байнгын ажилчид 15, улирлын чанартай түр ажилчид 25 байхаар тооцсон болно. Иймд тус баазаас амралтын үйл ажиллагааны явцад жилд 24.5 тн хатуу хог хаягдал ялгаран гарах тооцоотой байна. Жуулчны баазаас гарах хатуу хог хаягдлын эх үүсвэр нь зочид гийчдийн хэрэглээ, хоол бэлтгэлийн явц байх болно. Хатуу хог хаягдлын дийлэнх хувийг сав, баглаа, боодол эзэлнэ. Жуулчны баазаас доорхи нэр төрлийн хатуу хог хаягдал гарахаар байна. Үүнд:

- Хүнсний зүйлсийн сав, баглаа боодол
- Бие засах газрын хаягдал
- Пиво ундааны лааз болон бусад хаягдал
- Хоолны үлдэгдэл
- Бусад

Унд ахуйн усны хэрэглээ

Нийслэлийн Налайх дүүргийн Горхи-Тэрэлжийн БЦГ-т зүүн салаа нэртэй газар байрлах “Их халзан сүлжээ” ХХК-н ахуйн хэрэглээнд зориулан “Эрдэнэдрийминг” компаниар худгийн цооногийг 2019 оны 05 сарын 18-ны өдрөөс 2019 оны 05 сарын 19-ны өдөр хүртэл өрөмдөж гаргасан. Гүний худаг нь уртраг 107°25’02.80, өргөрөг 47°54’18.25 солбилцолд байрладаг. Худгийн цооногийн гүн 50м, Усны тогтсон түвшин 22м, усны ундарга 0.8 л/с байна.

Зураг 4.Худгийн байршил



Ажилчдын цэвэр усны хэрэглээ

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07-р сарын 30-ны өдрийн А301 Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм батлах тухай тушаалын 12 дугаар хавсралтаар ус түгээх байрнаас хангадаг ус хэрэглээний хоногийн дундаж норм 80 л/хон/хүн байдаг. Төсөлд нийт 10 ажилчин тогтмол ажиллана. Мөн нэг удаа 50 амрагч хүлээн авах хүчин чадалтай бөгөөд нормын дагуу 200л/хон ус ашиглана гэж үзэн усны хэрэглээг тооцсон. Нийт ресторан болон цомцог гэрийн цэвэрлэгээ хийх талбай нь 516м^2 байна.

Хүснэгт 7. Ундны усны хэрэглээний тооцоо

Усны зарцуулалт	Хэрэглэгдэх усны норм л/хоног	Хүний тоо	Жилд ажиллах хоног	Хоногт хэрэглэх усны хэмжээ м3	Сард хэрэглэх усны хэмжээ м3	Нийт усны хэрэглээ жил м3
Амрагч,	200 жуулчин,л/хон	70	90	14.0	2700.0	1260.0
Цэвэрлэгээ	8 л/м2	516	90	4.13	123.9	371.52
Нийт				18.13		1631.52

Ногоон байгууламж байгуулахад шаардлагатай усны хэрэглээ

Засгийн газрын хэрэгжүүлж буй "Тэрбум мод" үндэсний хөтөлбөр болон тоосжилтыг бууруулах, үйл ажиллагааны нөлөөллийг бууруулахад төслийн хүрээнд ногоон хөшиг байгуулах шаардлагатай. Харин төслийн талбайг зүлэгжүүлэх, мод тарих ажлын усалгааг БОНХАЖЯ-ны сайдын 2015.07.31-ий А/301 тоот тушаалын 13 дугаар хавсралтын Зүлэг, зам, талбайн усалгааны нормын зүлэг, цэцэг ногоо услах нормоор тооцов.

Хүснэгт 8. Ногоон байгууламж байгуулахад шаардагдах усны хэрэглээ

Усны зарцуулалт	Хэрэглэх усны л хоног	Тоо	Жилд услах хоног	Хоног м3	Нийт хэрэглээ жилд м3
Мод /Шилмүүст/	40	89	90	3.56	320.4
Зүлэгжүүлэлт	4	267 м	90	1.068	96.12
Нийт				4.628	416.52

Төслийн унд ахуйн хэрэгцээнд шаардлагатай усыг худгийн уснаас авч ашиглана.Ундны усны тооцоо 10*80л=800л/1000=0.8 м3 /хон

Харин ногоон байгууламжийн усыг өөрсдийн худгаас зөөврөөр хангаж усалгааг хийнэ. Мод усалгааны тооцоо 89ш модны усалгааг тооцохдоо 89*40л=3560л/1000=3.56м^3 7 хоногт 2 удаа услахаар 3.56м^3*2= 7.12м^3

Нийтдээ унд ахуйд 1631.52+ ногоон байгууламж усалгаа 416.52м^3 = 2048.04м^3 ус хэрэглэхээр байна. Ногоон байгууламжийн усыг дээврийн хур борооны усыг цуглуулж хуримтлуулж услахыг зөвлөж байна.

Хүснэгт 9. Усны 5 жилийн нийт хэрэглээ

Үзүүлэлт үүд	эх үүсвэр	Нэгж м^3		1-р жил	2-р жил	3-р жил	4-р жил	5-р жил	Нийт
Унд ахуйд	Ундны худаг 0.8 л/сек	Жилд	1631.52	1631.52	1631.52	1631.52	1631.52	1631.52	8157.6
		Хоногт	18.13	18.13	18.13	18.13	18.13	18.13	
Ногоон байгууламж		Жилд	416.52	416.52	416.52	416.52	416.52	416.52	2082.6
		Хоногт	4.628	4.628	4.628	4.628	4.628	4.628	
Нийт хэрэглээ	0.8 л/сек	Хоногт	22.76						10240.2

"Их халзан сүлжээ" ХХК -ийн Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн тур буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтай орон байр барих, ашиглах төсөлд 5 жилийн хугацаанд нийт 10240.2 м^3 ус шаардлагатай. Усны хэрэгцээг гүний 1 худгаас хангахаар төлөвлөсөн бөгөөд ундарга 0.8 л/сек байна. Хоногт 22.76 м3 ус хэрэглэх бөгөөд 0.2 л/сек ус шаардлагатай юм. Иймд одоо ашиглагдаж байгаа 0.8 л/сек худгаас хангах бүрэн боломжтой, нөөц хүрэлцээтэй байна.

Нийгмийн асуудал

Ажиллах хүчний тоо, эх үүсвэр

Уг төслийг хэрэгжүүлэхэд баазад 10 хүн ажиллана. Компанийн удирдлага зохион байгуулалт нь дараах бүтэцтэй байх бөгөөд доор заасан үүрэг зориулалтыг хэрэгжүүлэх болно.

Хүснэгт 10. Ажиллах хүчний тоо

№	Албан тушаал	Орон тоо
1	Баазийн ерөнхий зохион байгуулагч	1
3	Ахлагч тогооч	1
4	Туслах тогооч	1
5	Зөөгч бармен	2
6	Үйлчлэгч	2
7	Угаагч	1
8	Хаалгач	1
9	Манаач	1

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт 11. ***Байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын хураангуй***

№	Байгаль орчны бүрдэл	Товч тайлбар
1	Физик газарзүйн нөхцөл	Налайх дүүргийн нутагт талбай нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалын хувьд Хангайн их мужийн Хэнтийн муж 39-р тойрог буюу Хэнтийн захын тойрогт хамрагдаж байна *(Үндэсний атлас, 2009).* Энэхүү төслийн талбайд тархсан Бараан хөрс нь бохирдолгүй хэвийн байна.
2	Цаг уур уур амьсгал	Төсөл хэрэгжих бүсэд намар эрт сэрүүсэж, хавар хожуу дулаарч цасан бүрхүүл удаан хугацаагаар хадгалагдана. Цас бороотой өдрийн тоогоор бусад нутгаас хамгийн олон аянга цахилгаан 25 өдөр орчим 40 цаг үргэлжлэлтэй. Харин шороон шуурга хамгийн цөөн байдаг. Энэ үзүүлэлт нь 2000-д оны үеийнх бөгөөд эдүгээ дэлхийн хэмжээнд цаг уурын өөрчлөлт болж агаарын дулааны хэм нэмэх тал руугаа ихсэж чийгийн хэмжээ багасан харин хуурайшилт нэмэгдэж байгаа юм.
3	Гадаргын болон газрын доорх ус	Нийслэлийн Налайх дүүргийн Горхи-Тэрэлжийн БЦГ-т зүүн салаа нэртэй газар байрлах “Их халзан сүлжээ” ХХК-н ахуйн хэрэглээнд зориулан Нийслэлийн “Эрдэнэдрийминг” компанийн Дамбадорж менежер ахлагчтай анги/ бригадын супер 6000 маркийн сканокоор хийн цохилтод аргаар уул худгийн цооногийг 2019 оны 05 сарын 18-ны өдрөөс 2019 оны 05 сарын 19-ны өдөр хүртэл өрөмдөж гаргасан. Гүний худаг нь уртраг 107°25’02.80, өргөрөг 47°54’18.25 солбилцолд байрладаг. Худгийн цооногийн гүн 50м, Усны тогтсон түвшин 22м, усны ундарга 0.8 л/с байна.
4	Хөрсөн бүрхэвч	Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт байрлаж байна. Хэнтийн уулсын урд хэсэг, Туул голын эх Тэрэлж голын ай савыг бүхэлд нь хамарсан нутаг дэвсгэрт байрлана. Хойд хэсгийн уулархаг ой тайгатай газраар Хүлэрлэг цэвдэгт, Тайгын ширэгт хөрс илүү байдаг бол урд хэсгээр ойт-хээр, хээрийн бүсийн хөрс багагүй талбайд тархана. Туул Тэрэлж голын сав газраар Аллювийн хөрс, жижиг салаа гол бүхий хөндий хотос газраар хүлэрлэг, глейрхэг хөрс нэлээд их талбай эзэлнэ. Ерөнхийдөө уулархаг газар давамгайлдаг учраас хөрс нь чулуурхаг, уулсын орой, эгц налуу өвөр хажуугаар хад асга, чулуурхаг нимгэн хөрстэй.
5	Амьтны аймаг	Энэхүү төсөл хэрэгжих газар сүүлийн жилүүдэд тээврийн хэрэгсэл, хүний хөдөлгөөн ихсэж, дуу чимээний нөлөөлөл ихтэйгээс энэ бүст зэрлэг амьтан амьдрах боломж ерөнхийдөө хумигдсан байна.
6	Ургамлын аймаг	Байгалийн цогцолборт газарт 85 овогт хамаарах 389 төрлийн 1229 зүйл гуурст ургамлыг бүртгэжээ. Ургамалжилт нь өндөр уул, ойн, уулын хээрийн гэсэн босоо бүслүүрийн 3 үндсэн бүслүүр эрэмбэ үүсгэх бөгөөд уулсын оройгоор 2000 м-ээс дээш тагийн /гольцын/ бүслүүрт өндөр уулын тундрийн ургамлын элементүүд тархаж түүнээс доош шинэс-хушин ба алирс-гацууран зэрэг тайгын ой, түүнтэй залган шинэсэн ой тархсан байна. Горхи Тэрэлжийн БЦГ-т ургамалжилтын хувьд алаг өвс-улалжит, алаг өвс-үетэнт, шинэсэн ой, сургар-алирст, ногоон хөвдөт,

		алирс-бадаант хуш бүхий шинэсэн ой, алаг өвс-улалж-биелэг өвст, алаг өвст уулын хээр зонхилно. Ойн хил 1300-2200 м хүртэл үргэлжлэх ба шинэс, хус, улиас, гацуур голлоно. Нохойн хошуу төрөл бүрийн бургас, тавилгана, арц, тэрэлж, алирс, монос зэрэг сөөг ургана.
7	Тусгай хамгаалалттай газар нутаг	Горхи-Тэрэлжийн БЦГ-ын өвөрмөц тогтоц, үзэсгэлэнт байгалийг түшиглэн амралт, Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн тур буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтай орон байр барих, ашиглах төсөлууд олноор байгуулсан ба энэ газар Монгол улсын амралт, аялал жуулчлалын томоохон бүс болтлоо хөгжиж чадсан юм. Амралт, Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн тур буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтай орон байр барих, ашиглах төсөл, сууринууд нь зүүнээсээ баруун тийш 17 км, хойноосоо урагшаа 24 км үргэлжилсэн 408 км^2 буюу ойролцоогоор 40,8 мянган га талбай эзэлж байгаагийн 60 % орчмыг шинэсэн ой эзэлдэг.
8	Нийгэм эдийн засаг	Дэлхий нийтээр 2023 онд аялал жуулчлалын салбар Ковидын өмнөх буюу 2019 оны түвшинд хүрсэн. 2023 онд МУ-д 651,061 жуулчин ирсэн бол уг тоо 2024 онд 24%-иар нэмэгдэж 808,956 жуулчин ирсэн байна. 2024 оны зорилт 1 сая жуулчин хүлээн авах байсан бөгөөд гүйцэтгэл 81%-тай байсан нь чамлах тоо биш юм. Аялал жуулчлалын мэргэшсэн байгууллага болон үйлчилгээний газрын тоо жил бүр өсөн нэмэгдэж байгаа нь манай улсад аялал жуулчлалын салбар хөгжих нөхцөл бүрдэж байгааг харуулах нэг үзүүлэлт мөн боловч аяллын дэд бүтэц хөгжөөгүй, үйлчилгээний байгууллагуудын чадавх сул, тогтвортой уйл ажиллагаа явуулдаггүй, жуулчны баазуудын үйлчилгээний стандарт дээшилж тогтворжоогүй, аялал жуулчлалын бус нутгуудад хот ачаалал үүссэн зэрэг нь аялал жуулчлалын хөгжилд сөрөг нөлөөтэй гэсэн нийтлэг дүгнэлтүүд гарсан байна.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Төслийн болзошгүй нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

Төслийн болзошгүй ба гол сөрөг нөлөөллийг тогтооход байгаль орчны суурь нөхцөлийг тодорхойлох нь зүйтэй учир уг бүлгийг дараах хэсэгт ангилан бэлтгэв.

- Төсөл хэрэгжих орчны байгаль орчны, нийгэм эдийн засгийн суурь нөхцөл
- Төслийн гол сөрөг нөлөөлөл
- Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл

Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн тур буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтай орон байр барих, ашиглах төсөл байгуулах үйл ажиллагааны байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй нөлөөллийн үнэлгээг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 12. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нөлөөлөл хоорондын уялдаа

№	Нөлөөллийн төрөл	Шууд	Шууд бус	Богино хугацаагаар	Урт хугацаагаар	Бүцаж нөлөөлөх	Бүцалтгүй нөлөөлөх	Өөрөө зохицуулагдах	Хүчтэй	Дунд зэрэг	Сулавтар
1	Үйлчилгээний үйл ажиллагааг хангахтай холбоотойгоор байгаль орчин элэгдэл доройтолд орох (барилга байгууламж, асфальтан зам, эрчим хүч, дулаан, цэвэр, бохир усны нэгдсэн системд холбогдох шугам татах, суваг шуудуу ухах зэрэг)	+			+		+			+	
2	Амрагчид ойр орчимд дэмий сэлгүүцсэнээс газрын хөрс элэгдэх	+			+		+				+
3	Хатуу хог хаягдлын цэгийн байрлал, ил задгай байлгах болон шингэн хаягдлын шугам хоолой, түүний дамжуулах хоолойд гэмтэл гарах тохиромжгүй байдал (үнэр) үүсэх	+		+			+				+
4	Байгалийн үзэсгэлэнт объект (удган мод, хад цохио г. м) орчныг бохирдуулах, эвдэх		+		+		+				+
	баазын үйлчилгээний явцад бий болж болзошгүй нөхцөл: Хөдөлгөөн ихсэх (хүн, машин)	+		+			+			+	

5	Чимээ шуугиан ихсэх Авто машины дотоод шаталтын хөдөлгүүрийн хорт хийнээс агаарын бохирдол бий болох	+ +		+ +	+ 		+ 	 +			+ +
6	Удирдлага зохион байгуулалт, төлөвлөлтийн буруугаас орчин бохирдох, алдрал орох. Үүнд: Хөрс бохирдох Шинээр зөрөг зам гарах, хөрс дагтарших, эвдрэх Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муутайгаас ялаа шавж үржих Түймэр гарах	 + 	 + +	 + 	 + + +	 + 	 + + +	 	 +	 + + + +	
7	бааз орчмын хөрс элэгдэлд орох, дагтарших, ургамлын төрөл зүйл хомсдох	+			+		+			+	
8	Байгалийн гэнэтийн аюул	+			+		+		+		
9	Орчны менежментийн сургалт хангалтгүй		+	+					+		

Шууд нөлөөлөл. Болзошгүй нөлөөллийн ихэнх нь хамрагдах бөгөөд үүний улмаас төсөл хэрэгжих орчны байгалийн унаган төрх алдагдах, ялангуяа хөрс эвдрэх, хөрсний ус бохирдох, ургамал нөмрөг алдралд орох, салаа зам олшрох, хатуу хог хаягдал цуглуулах савыг ил задгай байлгах, эдгээрийг тогтмол зайлуулахгүй байх болон шингэн хаягдлын шугам хоолой, түүний нэгдсэн системд гэмтэл гарах зэргээр тохиромжгүй байдал (үнэр) үүсэх, явган зам жим олшрох зэрэг хамрагдана.

Богино хугацааны нөлөөлөл. Хог хаягдал зайлуулалд, ариутгал цэвэрлэгээ, хүн, авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, дуу шуугиан ихсэх, авто машины дотоод шаталтын хөдөлгүүрийн хорт хийнээс агаарын бохирдол бий болох зэрэг хамрагдаж байна.

Урт хугацааны нөлөөлөл. Төслийн бүтээн байгуулалтын ажил болон үйлчилгээтэй холбоотойгоор хөрсний дагтаршил, элэгдэл, эвдрэл, бохирдол, хөрсний усны бохирдол, гал түймэр зэрэг багтах бөгөөд эдгээр нь эргэж сэргээгдэхдээ удаан хугацаа шаардана.

Буцаж нөлөөлөх нөлөөлөл. Ахуйн хог хаягдалд зохих ариутгал хийгээгүй, хугацаанд нь зайлуулаагүй зэрэг тохиолдлоос шалтгаалж ялзарч өмхийрөн улмаар элдэв төрлийн халдварт өвчин гарч болзошгүй тохиолдлыг авч үзэж байна. Иймээс аливаа ариутгал цэвэрлэгээг энэ орчинд дор бүр нь хийж байхгүй бол ахуйн хатуу, шингэн хаягдал ихээр бохирдсоноос буцаж нөлөөлөх магадлалтай.

Буцалтгүй нөлөөлөл. Байгаль орчинтой холбоотой бүхий л үйл ажиллагааг хамруулан авч үзэж буй тул авто хөсгийн дотоод шаталтын хөдөлгүүрийн хорт хийнээс агаарын бохирдол бий болохоос бусад нь хамрагдаж байна.

Өөрөө зохицуулагдах нөлөөлөл. Авто машины дотоод шаталтын хөдөлгүүрийн хорт хийнээс агаарын бохирдол бий болох болзошгүй нөлөөллийг авч үзсэн бөгөөд, энэ нь нэгд үргэлжлэх хугацаа богино, зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй авто хөсгийн дотоод шаталтаас гарах хорт хий болон авто машины бензин шатахууны угаар хамрагдана.

Хүчтэй нөлөөлөл. Байгалийн гэнэтийн болзошгүй осолд тооцогддог нөлөөллүүд болох газар хөдлөл, хүчтэй салхи шуурга, анхаарал болгоомжгүйн улмаас гардаг ой, хээрийн түймэр орох бөгөөд энэхүү нөлөөлөлд нэрвэгдсэн байгаль орчин нь нөхөн сэргээгдэхдээ удаан хугацаа шаардахын зэрэгцээгээр байгаль орчныг хамгаалах урт хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулна.

Дунд зэргийн нөлөөлөл. Хөрс, хөрсний усанд бохирдуулагч бодис нэвчих, хүн ам, авто хөсгийн тоо ихэссэнээс ургамал нөмрөг алдралд орох, хог хаягдлыг ариутгах, зөөж тээвэрлэх ажил удаашрах зэрэг зүйлүүд орно.
Сулавтар нөлөөлөл. Төслийн үйл ажиллагааны орчиндоо амрагчид зохион байгуулалтгүй аялах зугаалах боломж гаргах, хөдөлгөөн, чимээ шуугиан ихсэх гэх мэт зүйлүүд орно.

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

“Их халзан сүлжээ” ХХК-ийн “Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн тур буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтай орон байр барих, ашиглах” төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаврыг бууруулах, урьдчилан сэргийлэх үүднээс үйл ажиллагаатай уялдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөлөө.
Тухайн төлөвлөгөөг БОАЖЯСайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах хянан батлах, тайлагнах журам”-ийн дагуу боловсруулсан.

БҮЛЭГ 5.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн бүр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглах бааз байгуулах төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг нэгтгэж доорх хүснэгтэд тусгалаа.

Хүснэгт 13. ***Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө***

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж
Агаарын чанар								
1	Авто тээврийн хөдөлгөөн ихэссэнээс агаар дахь тоосны хэмжээ CO, SO_2, NO_2 ихсэж, орчны хүчилтөрөгчийн /O_2/ хэмжээ багасах, үйлчлүүлэгч иргэд, аялагчдын автомашины шатах тослох материалын ууршилт, утаа тортог, хорт хий агаарт дэгдэж агаар орчинг бохирдуулах, ахуйн хог хаягдлын сав, бохир ус дамжуулах хоолой болон бохир ус цуглуулах хэсгийн битүүмжлэл муу байснаас үнэрийн бохирдол үүсэж болно.	Тээврийн хэрэгслийн хурдны хязгаарлалт, зам талбай, зогсоолын тэмдэг, тэмдэглэгээ, анхааруулгыг байршуулах	Талбайн хэмжээнд	Ш	10	30.0	300.0	9-р сард
2		Явган аялагчдын зам дагуу, бусад байгууламжууд болон гаднах зам, талбайн ахуйн хог хаягдлын савыг өдөр бүр суллан цэвэрлэж байх,	Талбайн хэмжээнд	М2		Өдөр тутмын үйл ажиллагааны зардалд орно	-	Өдөр бүр
		Хог хаягдал хадгалах зориулалтын цэг байгуулах	Талбайн хэмжээнд	-	-		200.0	9-р сард

	-Төслийн барилга байгууламж барих үеийн газар шорооны ажлаас тоосжилт үүсэх.							
Усны нөөц чанар								
3	Газрын доорх усыг ашигласнаар газрын доорх урсцын горим алдагдах	Худгийн тоолуурыг тоолууржуулах	Худаг	-	-	-	-	9-р сард
Хөрсөн бүрхэвч								
4	Төслийн барилгын ажлын үе шат, автомашины хөдөлгөөн, үйлчлүүлэгчдийн тоог хэт	Олон салаа зам, жим гаргах, орчны хөрс эвдрэхээс сэргийлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж, хяналт тавьж байх,	Талбайн хэмжээнд	-	-	-		Өдөр бүр
5	олшруулснаас хөрс, ургамал талхлагдах, элэгдэл, эвдрэл үүсэхээс гадна шатах тослох материал, хог хаягдал, бохирын шингэн алдагдсанаас хөрсөнд бохирдол үүсэж болзошгүй.	Төслийн объектууд хооронд явган хүний зам тавих (өнгөт хавтан, чулуу, хөндий банзан г.м), сэргээн засварлаж байх,	Явган зам	М2		1000.0		Төсөл хэрэгжих явцад
	Нийт					**1600.0**		

БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд 200 мод тарихаар төлөвлөсөн. Мөн орчны тохижилтын төлөвлөгөөний хүрээнд төслийн талбайд тарьсан модонд арчилгаа, тордлогоо хийхээр төлөвлөлөө.

Хүснэгт 14. ***Нөхөн сэргээх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө***

№	Нөхөн сэргээлтийн зорилго	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	Орчны тохижилт сайжруулах, арчилгаа тордлогоо хийх	Хайлаас	ш	7.0	200	1400.0	Төслийн хүрээнд	MNS 5918:2023 Байгаль орчин. Эвдэгдсэн газрын ургамлыг нөхөн сэргээх. Техникийн ерөнхий шаардлага
	Нийт				200	**1400.0**		

БҮЛЭГ 7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Их халзан сүлжээ” ХХК-ийн Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн бүр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглах төслийн талбай нь Горхи-Тэрэлжийн БЦГ-ын Зүүн салаа нэртэй газар 5000.0 м.кв талбайд байрлана. Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаанаас 2022 оны 11 сарын 28-ны өдрийн А/544 тоот санал буюу төсөл хэрэгжих талбай нь бусад газар ашиглагч нарын зөвшөөрөл бүхий газартай давхцалгүй болохыг тодорхойлсон бичиг авсан. Иймд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөхгүй юм.

БҮЛЭГ 8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн төлөвлөгөөний дагуу одоогоор түүх, соёлын өв илрээгүй. Төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллана.

БҮЛЭГ 9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах гол арга зам бол осол, эрсдэлийг гаргахгүй байх юм. Иймээс Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн бүр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглах төсөл нь галын аюулгүй байдлын хор байршуулах мөн байгаль орчинтой зөв зохистой харьцах мэдээллийн самбар байгуулахаар төлөвлөсөн. Эдгээр ажлын зардалд 650 000 төгрөг зарцуулах төлөвлөсөн.

Хүснэгт 15. Осол эрсдэлийг бууруулах,урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Цар, хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Ажлын байрны хөдөлмөр, эрүүл ахуйн нөхцөлийг хангаагүйгээс ажиллагсад болон, үйлчлүүлэгчдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх	Бохир усны цооног, бие засах газарт ариутгал халдваргүйжүүлэлтийг эрүүл ахуйн норм, дүрмийн дагуу тогтмол хийх	Төслийн хүрээнд	100.0	10-р сард	MNS 4244:1994 “Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага”
	Эдэлбэр газар үер, газар хөдлөлт, аянга, галын аюулгүй байдлыг хангасан хамгаалалттай, болзошгүй ослын үед ашиглах заавар, схем зургийг нүдэнд харагдахуйц газар ил байрлуулах, гал унтраах хор, хэрэгсэл, галын дохиог байгууламж бүр байрлуулах	Төслийн эхэнд	500.0	9-р сард	5390:2004 Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS 4968: 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага

	Байр сууцны ойр орчимд байгаль орчинтой зөв зохистой харьцах тухай санамжуудыг байрлуулах ба экологийн боловсролын хэсэг, булан байрлуулах	Төслийн эхэнд	50.0	9-р сард	MNS 4996:2000 Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих аргад тавих ерөнхий шаардлага
	Нийт зардал		**650.0 мян.төг**		

БҮЛЭГ 10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар баталсан хог хаягдлыг ангилан ялгах менежментэд хэвшүүлэх ажилчдад хог хаягдлыг яагаад ялгах тухай сургалтыг хийх, мөн ангилан ялгах зориулалттай хогийн савыг суурилуулах зэрэг ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөлөө.

Хүснэгт 16. ***Хог хаягдлын сөрөг нөлөөллийг арилгах бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө***

Байгаль орчныг хамгаалах арга	Тоо хэмжээ	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжих хугацаа	Баримтлах хууль, журам, стандарт
Хог хаягдлыг төрөлжүүлэн савлаж ангилан ялгах хогийн сав	3ш	95.0	9-р сард	Хог хаягдлын тухай хууль, хог хаягдлыг ангилан ялгаж хаях журам
Хог хаягдал болон бохирын цэгт тогтмол ариутгал хийх	Хагас жил тутам	250.0	10-р сард	
Хатуу хаягдлыг тогтсон цэгт түр хуримтлуулан орон нутгаас зааж өгсөн цэгт зайлуулах	Сард 2 удаа	500.0	10-р сард	MNS5344;2001 ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
нийт		845.0		

БҮЛЭГ 11. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр " Байгаль орчны менежментийг төлөвлөгөөний орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үүсэж болзошгүй өөрчлөлтийг хянах, шинжлэх объект, байршил, баримтлах стандарт, арга аргачлал, хугацаа, хариуцах этгээд, хяналт шинжилгээний үр дүнг тайлагнах талаар тодорхой тусгана" хэмээн Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-05 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 2.7-д заасан. Орчны хяналт шинжилгээний хүрээнд "Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн тур буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтай орон байр барих, ашиглах төсөл"- аас хөрсний цэг 1, усны 1 цэг, тус тус тусгаж өгөв.

Хүснэгт 17. ***Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр***

Бүрэлдэхүүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал төг/жил	Баримтлах стандарт ба арга аргачлал
Хөрсөн бүрхэвч	хөрсний үе давхаргын зузаан (см), элэгдэл эвдрэлийн нөхцөл, ялзмаг %, pH, давсжилт, Физик шинж чанар, органик бодис, нийт азот, карбонат, Ca, Mg, P2O5, K2O, хөрсний зарим хүнд металлын агууламж	Төсөл хэрэгжих талбай	9-р сард	Хөрсний механик бүрэлдэхүүн, ялзмаг 30.0 мян.төг Хөрсний хүнд металл шинжилгээний үнэ 45.0 мян.төг Хөрсний эрүүл ахуй 25.0	100.0	– MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл – MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох – MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам – MNS(ISO)4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх
Усан орчин	Усны pH, цахилгаан дамжуулах чадвар нүүрстөрөгчийн исэл CO_3, хүчил HCO_3, кальци Ca, хлор Cl, кали K, магни Mg, сод Na, хүхэр S, бор B, бари Ba, кадми Cd, кобальт Co, хром Cr, зэс Cu, төмөр	ундны усны эх үүсвэрээс,	9-р сард	Усны ерөнхий химийн шинжилгээ 68.0 мян.төг	68.0 мян.төг	– MNS0900:2005 Ундны ус-Ундны усны хяналт шинжилгээ – MNS3935:1986 Ундны ус-Усны шинжилгээнд тавигдах шаардлага – MNS3936:1986 Ундны ус болон үйлдвэрийн ус-Тухайн талбарт нь шинжилгээ хийх – MNS4432:1997 Ундны ус-Хуурай үлдэгдлийн хэмжээг тодорхойлох

	Fe, Хими бактериологийн бүрэн шинжилгээ					– MNS3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-Химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх – MNS5667-10:2001 Усны чанар-Дээж авах-2-р бүлэг. Хаягдал уснаас дээж авах – MNS5667-2:2001 Усны чанар-Дээж авах-2-р бүлэг Дээж авах арга – MNS4867:1999 Усны чанар-Дээж авах-3-р бүлэг Авсан дээжийг зөөвөрлөх, хадгалах арга
	Нийт				**174.0**	

БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 18. ***Удирдлага зохион байгуулалтаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө***

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2026 он				
			Сар 1.2.3.	Сар 4.5.6.7	Сар 8.9.10.11		
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах шатанд олон нийтийн оролцоог тэр дундаа төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог хууль тогтоомжид заасан хүрээнд аль болох өргөн хангах, тэдэнд ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит мэдээллийг өгч нээлттэй ажиллах.	300.0	Үйл ажиллагааны турш			БО мэргэжилтэн	“Байгаль хамгаалах тухай” хууль, “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 10.1 дэх заалт, БОНХС-ын 2013 оны А-126 тоот тушаал
	Нийт				300.0		

БҮЛЭГ 13.ТУХАЙН ЖИЛ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.

Хүснэгт 19. ***Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө***

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа тов	Тайлагнах зардал мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан	Зохион байгуулах газар
1	Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа,	ИНХ-д танилцуулах уулзалт	2026 онд хийгдсэн ажил	4 - р улирал	500.0	Захирал	Хан-Уул
	Нийт				500.0		

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ, ДҮГНЭЛТ

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 5 469 000 төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа мөнгө болгож 2 734 500 төгрөгийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9,15 дахь заалтад зааснаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулна.

Хүснэгт 20. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт

№	Мэдээллийн төрөл	Нийт зардал мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1600.0
2	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний төсөв	650.0
4	Орчны тохижилт төлөвлөлтийн зардал	1400.0
3	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төсөв	845.0
4	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	500.0
5	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	300.0
6	Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	174.0
	Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	**5469.0**

Барьцаа төлбөр

